



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/468

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 29 дүгээр зүйлийн 29.10.6, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК Хангайн бүсийн салбараас ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/575 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 1 дэх хэсгээр газар эзэмшигч хуулийн этгээд “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д эрчим хүч дамжуулах станцын зориулалтаар 6712014147 нэгж талбарын дугаартай 8890.3м² газрыг эзэмшүүлсэн бөгөөд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн эзэмшил газрын талбайн хэмжээ 8890.3м² газрыг 10843м² болгон өөрчилж үлдсэн 25 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/575 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 1 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч хуулийн этгээд “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК Хангайн бүсийн салбар (РД:2685221)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат)-т үүрэг болгосугай

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

